



**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО**

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 55,

Утас: 262449, 266246 Факс: (976-11) 32 52 34

И-мэйл: info@sport.gov.mn

2025.06.25 № 1/583
танай _____ -ны № _____ -т

**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАРТ**

Аймаг, нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороодын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 2.1, 2.2 дахь хэсгийг үндэслэн хяналт-шинжилгээ хийсэн тайланг хүргүүлж байна.

Хавсралт 3 хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Э.БИЛЭГТ



142530660

**АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР,
ХОРООДЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ
ХИЙСЭН ТАЙЛАН**

2025.06.23

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Аймаг, нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороодын 2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үндэслэл, үнэлгээний арга зүй

Монгол Улсын Засгийн Газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ыг удирдлага болгон 2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний 2025 оны эхний хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ хийлээ.

Байгууллага тус бүрийн биелэлтийг жилийн эцсийн зорилтот түвшин, үр дүнтэй харьцуулан үнэлсэн. Хяналт-шинжилгээний ажлын явцад зарим тайлан мэдээллийн хэрэгжилтийн байдалд нэмэлт тодруулга, хариуцсан албан тушаалтнаас тайлбар авах зэргээр мэдээллийн чанарыг сайжруулах, бататгах ажлыг гүйцэтгэв.

Гурав. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээний үр дүн

Биеийн тамир, спортын газар, хороодын 2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийг дүгнэхдээ дараах ангилалд шилжүүлэн тооцлоо. Үүнд:

- төлөвлөгөөний хэрэгжилт 85 буюу түүнээс дээш хувь бол “бүрэн хангалттай” (арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан, эсхүл шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн);
- төлөвлөгөөний хэрэгжилт 70-85 хүртэл хувь бол “хангалттай” (шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах);
- төлөвлөгөөний хэрэгжилт 70 хүртэл хувь бол “хангалтгүй” (удирдлага, зохион байгуулалт хангалтгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй нь баримтаар нотлогдсон.)

Аймаг, нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороодын нийт 31 байгууллага 2025 оны эхний хагас жилийн тайлан ирүүлсэн байх ба тайланд дурдсан 1218 арга хэмжээ дараах байдлаар дүгнэгдлээ.

**АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР ХОРООДЫН
2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
БИЕЛЭЛТЭД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ**

№	Аймаг, нийслэл, дүүрэг	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	2025 оны эхний хагас жилийн хэрэгжилт тайлагнавал зохих арга хэмжээ	Байгууллагын өөрийн үнэлгээ /хувь/	БТСУХ-ны ХШҮДАХ- ийн үнэлгээ /хувь/	Хэрэгжилтийн үр дүн
1	Архангай аймаг	7	27	23	92,3	85,5	Бүрэн хангалттай
2	Баян-Өлгий аймаг	7	56	49	78,8	75	Хангалттай
3	Баян-хонгор аймаг	7	60	52	90,59	86	Бүрэн хангалттай
4	Булган аймаг	8	45	45	94	84	Хангалттай
5	Говь-Алтай аймаг	5	29	26	95,4	85,6	Бүрэн хангалттай
6	Говьсүмбэр аймаг	7	67	62	93,43	86,4	Бүрэн хангалттай
7	Дархан-Уул аймаг	3	34	32	90,2	83,5	Хангалттай
8	Дорноговь аймаг	8	36	36	92,5	84,6	
9	Дорнод аймаг	5	37	34	82,2	80,6	
10	Дундговь аймаг	8	26	20	97	84,9	
11	Завхан аймаг	6	42	32	97,8	83,5	
12	Орхон аймаг	8	63	52	84	80,1	
13	Өмнөговь аймаг	4	32	32	89,3	81,5	
14	Өвөрхангай аймаг	7	33	27	97,5	85,3	Бүрэн хангалттай
15	Сүхбаатар аймаг	4	44	38	83,51	79,5	Хангалттай
16	Сэлэнгэ аймаг	6	53	44	97,8	84,3	Бүрэн хангалттай
17	Ховд аймаг	3	45	39	96,3	85,1	
18	Хөвсгөл аймаг	4	34	34	98,3	86,7	Хангалттай
19	Хэнтий аймаг	2	29	26	94,3	84,2	
20	Төв аймаг	3	27	26	98,57	83,7	
21	Увс аймаг	3	35	34	80	74,6	
22	Нийслэл	6	47	44	88	78,8	
23	Баянзүрх дүүрэг	3	49	40	70,87	70,5	
24	Баянгол дүүрэг	4	39	33	61,55	71,2	
25	Сонгинохайрхан дүүрэг	4	47	46	97,89	83,3	Бүрэн хангалттай
26	Чингэлтэй дүүрэг	6	26	20	100	85,1	
27	Хан-Уул дүүрэг	14	79	69	86,1	81,8	Хангалттай
28	Багануур дүүрэг	12	61	54	90,2	86,3	Бүрэн хангалттай
29	Багахангай дүүрэг	4	98	81	95,5	83,9	Хангалттай
30	Сүхбаатар дүүрэг	4	22	17	71,4	70,3	
31	Налайх дүүрэг	3	59	51	61,4	74%	
32	Нийт	175	1381	1218	88,6	81,6	Хангалттай

Дөрөв. Дүгнэлт

Аймаг, нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороодын 2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд батлагдсан 175 зорилт бүхий **1381** арга хэмжээнээс 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтээр тайлагнавал зохих **1218** арга хэмжээний биелэлтийг дүгнэхэд дундаж **81,6** хувьтай буюу “хангалттай” гэж үнэлэгдлээ.

Тав. Зөвлөмж: Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ.

1. Биеийн тамир, спортын газар, хороодын удирдлагууд төлөвлөгөөний заалт нэг бүрийн хэрэгжилт болон тайлан мэдээний боловсруулалт зэрэгт хяналт тавьж ажиллах;
2. Үйл ажиллагааны үр дүнг сайжруулах зорилгоор хэрэгжүүлэх хугацааг дахин нягталж хангалтгүй үнэлгээ авсан ажлуудын гүйцэтгэл, биелэлтийг хангуулах;
3. Урт хугацаагаар төлөвлөсөн үйл ажиллагааны арга хэмжээ нэг бүрийг сар, улиралд хуваарилан төлөвлөж гүйцэтгэлийг тухайн тайлант үеэр тооцож биелэлтийг ирүүлэх;
4. Төсөв, санхүүжилт шаардагдахгүй шийдвэрлэх боломжтой ажлуудыг эрчимжүүлэх, хугацаанд нь хэрэгжүүлж дуусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;
5. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнаж, хяналт-шинжилгээ хийхдээ Монгол Улсын Засгийн Газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ыг удирдлага болгох, мөн энэхүү хавсралт гурван журмын талаарх танилцуулгыг байгууллагын нийт албан хаагчдын дунд хийх;
6. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт, зорилтот түшиндээ нийцүүлэн, товч тодорхой, үнэн зөв тайлагнаж, хугацаанд нь хэрэгжүүлж, үр дүнг нэмэгдүүлж ажиллах;
7. “Бүрэн хангалттай” буюу 85-с дээш хувьтай үнэлэгдсэн арга хэмжээний үр дүнг цаашид бууруулахгүйгээр чанаржуулж, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах;
8. Тайлан мэдээний үг үсгийн алдаа, агуулга, боловсруулалт зэрэг дээр зөв бичгийн дүрмийг баримтлан албан бичгийн стандартад нийцүүлж хяналт тавьж ирүүлэх тал дээр анхаарч ажиллах;
9. Цаашид гүйцэтгэлийн арга хэмжээг төлөвлөхдөө хүрэх түвшинг хагас бүтэн жилээр тодорхой заахыг ыг тус тус зөвлөмжилж байна.

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Хянасан:

ХШҮДАХ-ийн дарга

Хяналт-шинжилгээ хийсэн:

ХШҮДАХ-ийн мэргэжилтэн

Э.БИЛЭГТ

Н.Батсүх

Д.Уранбилиг